



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/452

Мөрөн сум


Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалтаар аймгийн Засаг дарга эрүүл мэндийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгохыг түдгэлзүүлж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/480 дугаар тушаалаар ажлын хэсгийг Эрүүл мэндийн газар шилжүүлсэн тул аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “Комиссын бүрэлдэхүүн шинэчлэн байгуулах тухай” А/546 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН